



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2025.12.05 № 05/20662.
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төслийн удирдлагын газрын Төсөл, судалгааны хэлтсийн даргын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Самданхоролын Цэцэгмаагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч С.Цэцэгмаа нь тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан зарим шаардлагыг хангахгүй, мөн хүнд машин механизмын тоног төхөөрөмж, сэлбэгийн худалдаа, хүнд машин механизмын тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ, авто машинаар ачаа тээвэрлэх, уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх “Хонгорын эрдэнэс нэгдэл” ХХК, шахмал түлшний жижиглэн худалдаа, хөдөө аж ахуйн түүхий эд худалдаа, гахайн аж ахуйн үйл ажиллагаа, блок үйлдвэрлэл, газар тариалан эрхлэх үйл ажиллагааны чиглэлтэй “Зүүнбогдын оргил” ХХК, газар тариалангийн үйл ажиллагааны чиглэлтэй “Бага дөш хайрхан” нөхөрлөл, гадаад худалдаа, фермерийн аж ахуй эрхлэх, мал аж ахуй эрхлэх, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлтэй “Топ мийт комплекс” ХХК, ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлтэй “Цасхан мит трейд” ХХК-уудын эцсийн өмчлөгч, захирлаар бүртгэлтэй байх тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хориглолтыг хэрэгжүүлж, нийтийн албанд сул орон тоо гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан этгээдийг нэр дэвшүүлэхийг үүгээр зөвлөж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР



М.ДАВААТОГТОХ

Замуураа з/хзг/уу
сэг з/л-м
XII/09

142503022191